

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тонхил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/10/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ТОНХИЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА М.НАСАНБАТ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 03. 26 № 96

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тонхил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Тонхил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 177.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн, үйл ажиллагааны орлого 11.5 сая төгрөгөөр, шууд бус орлого 1.0 сая төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 1.9 сая төгрөгөөр, бууны албан татварын орлого 0.5 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татварын орлого 20.5 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 0.5 сая төгрөгөөр, торгуулийн орлого 3.3 сая төгрөгөөр тасарсан, малын тоо, толгойн албан татварын орлого болох 59.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй, Засаг даргын Тамгын газарт 3.0 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон нийт 101.8 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Тонхил сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 10 дугаар тогтоолын 1 дэх заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 10/683 тоот албан бичгийн хавсралтаар Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийг ирүүлсэн байна.

0702900463

Аудитын гол асуудал

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,524.3 сая төгрөг буюу 84.6 хувьтай байна. Энэ нь төлөвлөснөөс Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг 148.6 сая төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг 105.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 74 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 80 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 90.9 хувийн биелэлттэй гаргаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 90.9 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	889,181.8	688,370.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,141,975.7	2,202,896.9
Нийт хөрөнгийн дүн	3,031,157.5	2,891,267.3
Нийт өр төлбөрийн дүн	2,000.0	3,780.3
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,029,157.5	2,887,487.0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,031,157.5	2,891,267.3
Үйл ажиллагааны орлогын дүн	3,559,404.3	1,583,502.1
Үйл ажиллагааны зардлын дүн	1,790,116.4	1,488,182.5
Үйл ажиллагааны үр дүн	1,769,287.9	95,319.6
Үйл ажиллагааны бус үр дүн	2,725,598.4	500,563.1
Үйл ажиллагааны нийт үр дүн	(956,310.5)	(405,243.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	3,029,157.5	2,887,487.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,985,468.0	3,292,730.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
Тайлант оны үр дүн	(956,310.5)	(405,243.5)
Эцсийн үлдэгдэл	3,029,157.5	2,887,487.0
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,141,203.0	1,631,354.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,714,029.4	1,238,839.1
Үйл ажиллагааны ЦМГ	427,173.6	392,515.8
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(502,694.7)	(336,724.5)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	(46,000.0)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(75,521.1)	9,791.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,195,125.9	1,524,308.4
Урсгал зардал	692,431.2	1,171,483.9
Хөрөнгийн зардал	502,694.7	306,824.5
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	-	46,000.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,242,929.1	1,554,828.9
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,164,652.1	1,472,965.3
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	78,277.1	81,863.5



Гурав. Аудитын илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,681,072.9 мянган төгрөгийн 12 алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан байна.

Аудитаар нийт 279,729.5 мянган төгрөгийн 20 зөрчил илрүүлснээс 98717.4 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 181,012.1 мянган төгрөгийн зөрчилд зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 15 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Залруулагдаагүй зөрчлийн дүн 279,729.5 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 36,026.0 мянган төгрөгөөс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 5 байгууллагын (Сургууль, Бага сургууль Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Бага сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

5.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайланг 448,562.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 6 алдааг залруулж, 85,282.7 мянган төгрөгийн 6 зөрчил илрүүлснээс 39,282.7 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 46,000.0 мянган төгрөгийн 3 зөрчилд зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

5.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайланг 199,710.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 3 алдааг залруулж, 92,569.0 мянган төгрөгийн 10 зөрчил илрүүлснээс 92,569.0 мянган төгрөгийн 9 зөрчилд зөрчил арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар санхүүгийн тайланг 1,032,800.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 3 алдааг залруулж нийт 101,877.8 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлж 59,434.7 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 42,443.1 мянган төгрөгийн зөрчилд зөрчил арилгах, давтан гаргахгүй 3 албан шаардлага хүргүүлсэн байна.

5.2.1 Төлбөрийн акт

1. Малын тоо, толгойн албан татварын орлого 59,434.7 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны

зардалд зарцуулна." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй малын хөлийн албан татварыг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2.2 Албан шаардлага

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд үйл ажиллагааны орлого 11,568.3 мянган төгрөгөөр, шууд бус орлого 1,036.7 мянган төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 1,920.5 мянган төгрөгөөр, бууны албан татварын орлого 538.0 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татварын орлого 20,565.3 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 494.3 мянган төгрөгөөр, торгуулийн орлого 3,320.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 22 дугаар тогтоол," гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр ханган ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Батлагдсан төсвөөс Засаг даргын тамгын газарт санхүүжилтийг олгохдоо 3,000.0 мянган төгрөгийн санхүүжилт илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16-т "төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох; 41 дүгээр зүйлийн 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 10 дугаар тогтоол" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн дагуу санхүүжилтийг олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Төсвийн төвлөрүүлэн захирагчид нэгтгэгддэг нэгж байгууллагуудад залруулагдаагүй 177,851.7 мянган төгрөгийн 16 зөрчил илэрч 28,282.7 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 149,569.0 мянган төгрөгийн 13 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг

сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх
албан шаардлага хүргүүлэв.



4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тонхил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	368,560.5	-	-	1	368,560.5	1	368,560.5	-	-
Тонхил сумын Засаг даргын Тамгын газар	6	112,130.1	-	-	6	112,130.1	6	112,130.1	-	-
Тонхил сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	3,380.0	-	-	1	3,380.0	1	3,380.0	-	-
Дүн	8	484,070.6	-	-	8	484,070.6	8	484,070.6	-	-



4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтийн	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түвшэрт	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
							Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
									Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тонхил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	-	1	-	-	-	3	8,533.9	1	6,714.5	2	1,819.4	-	-
Тонхил сумын Засаг даргын Тамгын газар	1	1	-	-	-	-	1	8,056.8	-	-	1	8056.8	-	-
Тонхил сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	-	-	-	1	2	7,727.0	-	-	2	7,727.0	-	-
Тонхил сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	-	1	2	80,199.4	1	29,320.5	1	50,878.9	-	-
Тонхил сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Тонхил сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Дүн	6	2	-	-	-	4	8	104,517.1	2	36,035.0	6	68,482.1	-	-

